

**Нэр томъёоны тодорхойлолтыг стандарт шаардлагын үүднээс
задлан шинжлэх нь**

(МУ-ын стандартчилсан нэр томъёоны жишээгээр)

Намсрайн МӨНХЦЭЦЭГ*

*Монгол Улс, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн
Хэрэглээний хэл шинжлэлийн салбар*

Received: Sept 14, 2023

Revised: Nov 25, 2023

Accepted: Dec 14, 2023

Хураангуй: Шинжлэх ухаан, технологи, нийгэм эдийн засгийн салбар бүрд шинэ мэдлэг, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэрлэсэн олон зуун нэр томъёог боловсруулах, журамлах, жигдлэн стандартчилах шаардлагатай болсон. Үүнтэй уялдан Монгол Улсын стандартад нэр томъёоны үүрэг, ач холбогдол улам бүр ихсэж байна. Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй 6747 стандартын 550 орчим нь нэр томъёоны стандарт байна. Үүнээс гадна бусад стандарт ч дотроо нэр томъёо, тодорхойлолттой байдаг.

Энэхүү өгүүлэл нь дээрх хэрэгцээ шаардлагыг хангах зорилгоор гүйцэтгэж буй суурь судалгааны төслийн хүрээнд стандарт дахь нэр томъёоны тодорхойлолтуудыг нэр томъёоны стандартын дагуу боловсруулагдсан эсэхийг агуулгын болон хэлбэрийн талаас нь шинжлэн судлахыг зорьсон болно.

Судалгаанаас үзэхэд, нэр томъёоны тодорхойлолтын бичилт нь нэгдсэн стандартгүй, агуулга, хэлбэрийн хувьд алдаа дутагдал их байна. Бид эдгээр асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар саналаа дэвшүүлсэн болно.

Түлхүүр үг: нэр томъёоны стандарт шаардлага, тодорхойлолт, ухагдахуун, агуулга, хэлбэр

* © Н.Мөнхцэцэг
Email: munkhtsetsegn@mas.ac.mn

Analyzing Definitions of Terms in Terms of Standard Requirements

MUNKHTSETSEG Namsrai

Department of Applied Linguistics, the Institute of Language and Literature,
Mongolian Academy of Sciences, Ulaanbaatar, Mongolia

Abstract: *In every field of science, technology, and social economy, it is necessary to develop, regulate, and uniformly standardize hundreds of terms that name new knowledge, new products, and services. Thus, the role and importance of terminology in Mongolian standards is increasing more and more. It is said that about 550 of the 6747 standards in Mongolia are terminology standards. In addition, other standards have terms and definitions within them.*

Within the framework of the basic research project, this article aims to analyze whether the definitions of standardized terms have been developed in accordance with the terminology standards in terms of content and form.

According to the research, the entry of definitions of terms does not have a unified standard, and there are many errors in content and form. We have put forward suggestions on how to solve these problems.

Key words: *term standard requirements, definition, concept, content, form*

1. Удиртгал

Даяаршлын эрин үед дэлхийн шинжлэх ухаан, технологи хурдацтай хөгжиж байгаатай уялдан мэдлэгийн үүрэг шинэчлэгдэж, эдийн засаг, үйлдвэрлэлийн нэг чухал хүчин зүйлд тооцогдох болов. Шинжлэх ухаан, технологи, нийгэм эдийн засгийн салбар бүрд шинэ мэдлэг, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэрлэсэн олон зуун нэр томъёог боловсруулах, журамлах, жигдлэх шаардлагатай болсон. Үүнтэй уялдан Монгол Улсын стандартад нэр томъёоны үүрэг, ач холбогдол улам бүр ихсэж байна. Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй 6747 стандартын 550 орчим нь нэр томъёоны стандарт байна. Үүнээс гадна бусад стандарт ч дотроо нэр томъёо, тодорхойлолттой байдаг.

Стандартчилсан нэр томъёо нь нийгмийн аюулгүй байдал; мэргэжлийн салбарын харилцаа; дээд боловсрол, мэргэжлийн сургалт; мэдээлэл, түүний баримтжуулалт; шинжлэх ухааны бүтээл туурвил ба техникийн баримтжуулалт; мэдлэгийн инженерчлэл; мэдлэг ба технологи дамжуулалт зэрэгт чухал үүрэг гүйцэтгэдэг” (Galinski, 1995).

Тиймээс энэ бүх асуудлыг үе шаттай, тогтолцоотой засаж сайжруулах, нэр томъёоны стандартыг боловсронгуй болгохын тулд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй стандартуудаас нэр томъёог түүвэрлэн авч хөмрөг үүсгэн нэр томъёо судлал, хэл шинжлэлийн талаас нь судлан задлан шинжилж, судалгааны бүтээл бичих, судалгааны үр дүнд зөвлөмж гаргаж, олон нийтэд хүргэх хэрэгтэй юм.

Энэхүү өгүүлэл нь дээрх хэрэгцээ шаардлагыг хангах зорилгоор

гүйцэтгэж буй суурь судалгааны төслийн хүрээнд стандарт дахь нэр томъёоны тодорхойлолтуудыг нэр томъёог боловсруулах арга зарчмын стандартын дагуу боловсруулагдсан эсэхийг шинжлэн судлахыг зорьсон болно.

2. Судалгааны арга зүй

Энэхүү судалгаанд барилга, эрчим хүч, зам тээвэр, худалдаа, хүнс, аж үйлдвэр, ойн аж ахуй, усан хангамж, шуудангийн үйлчилгээ, ургамал хамгаалал, техник, технологи зэрэг салбарын 85 стандартын 10421 нэр томъёо, тодорхойлолт бүхий хөмрөг¹-ийг Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Ажлын албатай хамтран бүрдүүлэн ашигласан болно.

Хөмрөгт буй нэр томъёоны тодорхойлолтуудыг агуулгын хувьд задлан шинжлэхдээ тус өгүүллийн 4.1 хэсэгт хоёр өөр нэр томъёог нэг ижил тодорхойлсон, нэг нэр томъёог хоёр өөрөөр тодорхойлсон, хэт ерөнхий, хэт нарийвчилсан, тойрог, нэр томъёоны хувилбар мэт хэт богино тодорхойлолт, найруулгын алдаатай тодорхойлолт, сөрөг утгатай тодорхойлолтыг механик аргаар тоолон, тэдгээрээс жишээ баримтаар баяжуулан тайлбарлаж, алдааг эрхэн засаж залруулах талаар өөрийн саналыг бичсэн болно.

Хэлбэрийн талаас задлан шинжлэхдээ, тодорхойлолтын бичилтийн олон янз байдлыг ангилан, алдаатай тодорхойлолтуудын тоог механикаар болон корпус хэл шинжлэлийн AntConc программыг ашиглан гаргаж, жишээ баримтаар тайлбарлан, хэрхэн засаж бичих талаар өөрийн саналыг дэвшүүлээ.

3. Нэр томъёоны тодорхойлолтын тухай ерөнхий ойлголт


Тодорхойлолт нь нэр томъёоны үндсэн бүрэлдэхүүн хэсгийн нэг юм. Тодорхойлолтгүй нэр томъёо гэж байхгүй. Өөрөөр хэлбэл, нэр томъёог үгээс ялгах гол шалгуур нь тодорхойлолт юм. Нэр томъёоны тодорхойлолт бол тухайн нэр томъёогоор илэрч буй ухагдахууныг ойлгож, танин мэдэхэд чухал ач холбогдолтой. Тодорхойлолт гэдэг нь “Ухагдахууныг бусад холбогдох ухагдахуунаас ялгахын тулд шинжээр нь тодорхойлон бичсэн өгүүлбэр” (ISO 1087-1: 2019) юм. Энгийн үгээр хэлбэл, тухайн юм үзэгдлийн онцлог шинжийн нэгдэл буюу ухагдахууныг зөв оновчтой, бүрэн гүйцэд илэрхийлсэн тайлбар юм.

ISO 10241-1 стандартад “Тодорхойлолт нь ухагдахууныг тодорхойлсон өгүүлбэр бөгөөд ухагдахууны тогтолцоон дахь тухайн ухагдахууны байр суурийг тусгадаг” бөгөөд “тухайн ухагдахууныг (3.2.1) холбогдох ухагдахуунуудаас ялгах зорилгоор дүрслэн тайлбарладаг” хэмээжээ.

Нэр томъёоны тодорхойлолтын олон янзын тодорхойлолт байдаг. Жишээ нь: “...тухайн нэр томъёоны утгыг тодорхойлсон ганц өгүүлбэр бөгөөд тодорхойлолтод нэр томъёо нь өөрөө ороогүй байдаг” (Seppälä, 2015: 25).

¹ www.terminology.mn цахим сайтад буй.

Флорос², Грамменидис³ нар (2012) тодорхойлолт нь ухагдахуун, нэр томъёог холбоход гол үүрэг гүйцэтгэдэг хэмээн дурдаад дараах схемээр үзүүлсэн байна.



Зураг 1. Флорос, Грамменидисийн схем (2012)

Зургаас үзэхэд, тодорхойлолт нь ухагдахуун, нэр томъёо хоёрын дунд зуучийн буюу дамжуулах түвшний үүрэг гүйцэтгэдэг болохыг дүрээлсэн байна. “... Нэр томъёоны хувьд тодорхойлолт нь ерөнхий үгийн сангийн тодорхойлолттой харьцуулахад, ухагдахууныг илүү тодорхой тайлбарладаг бөгөөд тэмдэглэгдэхүүн ба тэмдэглэхүүн хоёрын дунд илүү “тогтвортой” холболтыг бий болгодог” (Floros, Grammenidis, 2012). “Нэр томъёоны үүднээс тодорхойлолт нь хэлний илэрхийллийн тусламжтайгаар ухагдахуун ба нэр томъёоны хоорондын харилцааг тогтворжуулдаг” (Salgado, Costa, and Tasovac, 2022: 189).

Тиймээс нэр томъёоны тодорхойлолтыг нэр томъёо, ухагдахуунаас бүрдсэн “нэгж”-ийн нэг хэсэг гэж үздэг.

В.Ф.Новодранова “Тодорхойлолт нь үгийн сангийн нэгж нэр томъёо мөн эсэхийг тодорхойлох үндэслэл болно гэж тэмдэглээд “хэрэв тодорхойлолт нь тусгай мэдлэгийг бус, харин энгийн ойлгомжтой ойлголтыг тэмдэглэж буй бол энгийн үг; хэрэв тодорхойлолт нь тусгай мэдлэгийн нэгжийг тэмдэглэж буй бол нэр томъёо болно” (Новодранова, 2008: 89) хэмээжээ. Тиймээс “Үг ба нэр томъёоны ялгаа нь оюуны үйл ажиллагааны өөр өөр түвшинд буюу шинжлэх ухааны мэдлэгийн салбарт юм уу эсвэл өдөр тутмын үйл ажиллагааг тэмдэглэж байгаагаас шалтгаална” (Гринев-Гриневич, 2008: 86) хэмээн тэмдэглэсэн байна. Үүнээс үзвэл, нэр томъёоны тодорхойлолт нь нэр томъёог жирийн үгээс ялгах хэрэгсэл болох бөгөөд ямар нэг ухагдахууныг ойлгож таньж мэдэхэд ач холбогдол бүхий мэдээлэл агуулсан өгүүлбэр болно.

1.1. Нэр томъёоны тодорхойлолтын ангилал

Нэр томъёоны тодорхойлолтыг янз бүрээр ангилсан байдаг. Вений дэг сургуулиар агуулгын тодорхойлолт (intensional definition), хүрээний тодорхойлолт (extensional definition), хэсэг-бүхэл (part-whole) гэж тодорхойлолтыг гурав ангилдаг. Агуулгын тодорхойлолт нь нөгөө хоёр төрлөөс илүү тогтолцоотой

² Georgios Floros

³ Simos Grammenidis

байдаг бөгөөд тодорхойлогдож буй ухагдахууны шинжүүдийг тодотгодог (Felber, 1984). Олон улсын ISO 704: 2022 стандартаар нэр томъёоны тодорхойлолтыг агуулгын, хүрээний гэж үндсэн хоёр төрөлд хуваажээ.

Агуулгын тодорхойлолт гэж ухагдахууны дотоод агуулга, онцлог, шинж чанарыг тодорхойлон тайлбарласан, шууд бус буюу коннотац утгатай өгүүлбэр юм. Жишээ нь: **худалдагч**: *Барааг худалдан борлуулах үүрэг бүхий, жижиглэнгийн худалдааны газрын үндсэн ажилтан* (MNS 5364:2011) Хүрээний тодорхойлолт гэж тухайн ухагдахууны хүрээг зааж, дэд ухагдахууныг тоочсон, шууд буюу денотац утгатай өгүүлбэр юм. Жишээ нь: **ховордсон зүйл**: *эмзэг, устаж болзошгүй, устаж байгаа зүйлс*⁴ (Мөнхцэцэг, 2020: 22) гэх мэт. Агуулгын тодорхойлолтын үүрэг нь ухагдахууныг таних, түүнийг бусад ухагдахуунаас, ялангуяа зэрэгцээ ухагдахуун (coordinate concept)-аас ялгах мэдээллээр хангах явдал юм (ISO 704: 2022). Харин хүрээний тодорхойлолтыг маш хязгаарлагдмал нөхцөлд хэрэглэдэг. Үүнд:

- дэд ухагдахууны тоо хэмжээ хязгаартай үед;
- дэд ухагдахууны жагсаалтыг нэг шалгуураар гаргах тохиолдолд;
- дэд ухагдахууныг агуулгын тодорхойлолтоор тодруулж болох тохиолдолд юм уу эсвэл сайн мэддэг тохиолдолд хэрэглэдэг (ISO 704: 2022).

Хүрээний тодорхойлолтыг ерөнхий хүрээний тодорхойлолт (generic extensional definition), хэсэгчилсэн хүрээний тодорхойлолт (partitive extensional definition) гэж ангилдаг. Ерөнхий хүрээний тодорхойлолт гэдэг нь ерөнхий ухагдахуун (generic concept)-д багтах бүх тусгай ухагдахуун (specific concept)-ыг шатлалын ижил түвшинд дэд ангиллын нэг шалгуураар жагсаасан тодорхойлолтыг хэлнэ. Жишээ нь: “Инерт хий: гелий, неон, аргон, криптон, ксенон эсвэл радон”⁵ (ISO 1087: 2019). Хэсэгчилсэн хүрээний тодорхойлолт гэдэг нь бүхэл ухагдахуун (comprehensive concept) дахь бүх хэсэгчилсэн ухагдахууныг нэг шаталсан түвшинд жагсаасан тодорхойлолтыг хэлнэ. Жишээ нь: “Үелэх системийн 18-р бүлэг: гелий, неон, аргон, криптон, ксенон ба радон” (ISO 1087: 2019). Энэхүү ангиллаас гадна олон янзаар ангилсан байдаг. Гэвч бидний энэ судалгаа нь тодорхойлолтын ангиллыг дэлгэрэнгүй авч үзэхийг зорьсонгүй, харин нэр томъёоны стандарт шаардлагын хүрээнд бичигдсэн эсэхийг судлахад чиглэнэ.

1.2. Нэр томъёоны тодорхойлолтын стандарт шаардлага

Тодорхойлолтыг боловсруулах нь цаг хугацаа их шаарддаг боловч ухагдахууны талаар мэдээлэл өгдөг тул нэр томъёо бүр тодорхойлолттой байх ёстой. “Нэр томъёо судлалд сайн тодорхойлолт нь тухайн ухагдахууны шинж чанарыг илэрхийлэх замаар тодорхой ухагдахууны тогтолцоон дахь түүний байр суурийг тодотгох, ангилахад тустай” (Faber, Martinez, 2019), “Сайн тодорхойлолт нь тухайн ухагдахууны үндсэн ба онцлог шинж чанарыг тодотгосноороо

⁴ *A threatened species is any species which is vulnerable, endangered, or critically endangered.*

⁵ *Noble gas: helium, neon, argon, crypton, xenon or radon.*

бусад холбогдох ухагдахуунаас юугаараа ялгаатай болохыг тодорхойлж, нэг ухагдахууныг нөгөөгөөс хоёрдмол утгагүйгээр тэмдэглэдэг” (TerminOrgs, 2016) гэх мэтээр тодорхойлолтын зөв, оновчтой бичихийн чухлыг дурдсан байна.

Ялангуяа арга зүйн хувьд зорилтот хэлэнд хоёрдогч нэр томъёо бүтээх (орчуулах)-д чухал ач холбогдолтой. Тодруулбал, нэр томъёог өөр хэлээр орчуулахад тухайн ухагдахууны талаар ойлгож, нэр томъёо онооход тодорхойлолт нэн чухал. Тиймээс нэр томъёоны тодорхойлолт ямар байх ёстой талаар нэр томъёо судлаачид онцлон тэмдэглэсэн байдаг. Тухайлбал, Австрийн нэр томъёо судлаач Весна Лусики⁶, Тая Виссик⁷ нар (2015: 40-41) дараах шаардлагыг дурдсан байна. Үүнд:

- Тогтолцооны лавлагаа: тодорхойлолт нь ухагдахууныг аль ухагдахууны тогтолцоонд орохыг заадаг.
- Товч байх: тодорхойлолт нь товч боловч тухайн ухагдахууны бүх чухал онцлог шинж чанарыг тодорхойлсон байх ёстой.
- Батлах шинж: тодорхойлолт нь юу биш болохыг бус, харин юу болохыг илэрхийлдэг.
- Тойрог бус байдал: тодорхойлолтод тухайн ухагдахууныг нэрлэсэн нэр томъёог хэрэглэдэггүй, мөн түүгээр эхэлдэггүй.
- Учир зүйн давталтгүй байх: тодорхойлолт нь нэр томъёог дахин давтахгүй, харин ухагдахууны утгын шинж чанарыг тайлбарладаг.
- Орлуулах чадвар: тодорхойлолтыг тухайн тодорхойлуулж буй нэр томъёотой ижил үгийн аймаг бүхий үгээр төгсгөх ёстой.

Стандартчиллын хүрээнд хийгдсэн нэр томъёоны ажлын хувьд нэр томъёо болон тодорхойлолт, бусад нэрлэлтийг стандартчилдаг. Нэр томъёоны стандартыг “Тодорхойлолт бүхий нэр томъёо болон тайлбар тэмдэглэл, зураг дүрс, жишээ гэх мэтгэй холбоотой стандарт” (ISO 10241-1: 2011) хэмээн тодорхойлжээ.

Тодорхойлолтын төслийг боловсруулахдаа ISO 704 стандартад заасан ерөнхий дүрэм, зарчим дээр үндэслэнэ. Тодорхойлолт нь ухагдахууны тогтолцоон дахь тухайн ухагдахууны байр суурийг тусгаж, шинж чанарыг онцлон тодорхойлсон ганц өгүүлбэр байх ёстой. Энэ шаардлагыг агуулгын тодорхойлолт хамгийн сайн хангаж чадна (ISO 860: 2007). Агуулгын тодорхойлолтын үндсэн хэсэг нь тухайн ухагдахуунд хамаарах дээд ухагдахууныг хоёр дахь хэсэгт буй зэрэгцээ ухагдахуунуудаас ялган зааглах шинж чанарыг тоочин бичдэг.


Олон улсын ISO 704:2022 стандартаар нэр томъёоны тодорхойлолтод агуулгын хувьд дараах дүрмийг баримтлахыг шаарддаг. Үүнд:

1. Тодорхойлолт нь тодорхойлж буй ухагдахууныг ижил төстэй ухагдахуунаас заагласан байх ёстой. Энэ шаардлагыг хангахын тулд тодорхойлолт нь тухайн ухагдахууны зөвхөн чухал буюу бусдаас онцлог шинж чанарыг агуулсан байх ёстой.

⁶ Lušicky, Vesna,

⁷ Tanja Wissik

2. Тодорхойлолт нь ухагдахуунтай пропорциональ байх ёстой, өөрөөр хэлбэл, хэт ерөнхий юм уу эсвэл хэт нарийвчилсан байх ёсгүй.
3. Тодорхойлолт нь учир зүйн тойргийг үүсгэж болохгүй. Өөрөөр хэлбэл, тодорхойлуулж буй нэр томъёог ашиглан тодорхойлж болохгүй. Хэрэв нэг ухагдахууныг тодорхойлохдоо, тухайн ухагдахууныг илэрхийлэх ий ба тэмдэглэгээний махбодыг ашиглан тодорхойлсон бол түүнийг тойрог тодорхойлолт гэж нэрлэдэг. Тойрог тодорхойлолтыг дүрсэлбэл, дараах байдалтай байна.



Зураг 2. Тойрог тодорхойлолтын загвар. Эх сурвалж: <https://www.wikiwand.com>

Зураг 2-оос үзэхэд, **“Тойрог тодорхойлолт гэж тойрог тодорхойлолт юм”* гэсэн өгүүлбэрийг жишээ болгоод тойрог хэлбэрээр дүрсэлжээ. Ийм төрлийн тодорхойлолт нь тухайн ухагдахууныг ойлгомжгүй болгодог.

4. Тодорхойлолтод тэмдэглэсэн шинж чанар нь бие биеэ үгүйсгэсэн болон учир зүйн хувьд зөрчилдсөн байх ёсгүй.
5. Тодорхойлолт нь сөрөг утгатай байх ёсгүй. Ийм тодорхойлолт нь ухагдахуунд байхгүй шинж чанарыг тэмдэглэсэн байх тул ухагдахууны агуулгыг төдийлөн илэрхийлж чаддаггүй. Тодорхойлолтын зорилго нь энэ зүйл юу вэ гэсэн асуултад хариулах бөгөөд үүний тулд ухагдахууны чухал шинж чанарыг эерэг хэлбэрээр тусгах ёстой.

Тодорхойлолтын хэлбэр нь хам сэдэвт тухайн нэр томъёог сольж болохуйц байх ёстой. Нэмэлт мэдээллийг зөвхөн жишээгээр эсвэл тэмдэглэлд оруулна. Тиймээс хэлбэрийн хувьд дараах дүрмийг баримтална. Үүнд,

- а) Тодорхойлолтын төгсгөл нь нэр томъёотой ижил хэл зүйн хэлбэртэй байна. Тиймээс үйл үгийг тодорхойлохдоо үйл үгээр; нэр үгийг тодорхойлохдоо нэр үгээр төгсгөх ба нэр нэр томъёог тодорхойлохдоо ганц тоог хэрэглэнэ.
- б) Тодорхойлолт нь тодорхойлох гэж буй нэр томъёо буюу тэмдэглэх нэр томъёогоор эхэлж болохгүй. Өөрөөр хэлбэл, “/Нэр томъёо/ нь, гэж, гэдэг нь ...” гэсэн хэлбэртэй байж болохгүй. Жишээ нь: **Тодорхойлолт нь ухагдахууныг бусад холбогдох ухагдахуунаас ялгахын тулд шинжээр нь*

тодорхойлон бичсэн өгүүлбэр гэж бичихгүй гэсэн үг. Зүй нь “Ухагдахууныг бусад холбогдох ухагдахуунаас ялгахын тулд шинжээр нь тодорхойлон бичсэн өгүүлбэр” гэж бичих ёстой.

- с) Тодорхойлолт нь тодорхойлох гэж буй нэр томъёо буюу тэмдэглэх нэр томъёогоор төгсөж болохгүй (ISO 704: 2022) гэх мэт шаардлагыг бичжээ.

Хамгийн чухал нь тодорхойлолт бол энгийн, товч (ихэвчлэн нэг өгүүлбэр) оновчтой бөгөөд зөвхөн чухал мэдээллийг агуулсан, тухайн ухагдахууны онцлог шинжийг тодорхой дүрсэлсэн байх ёстой. Нэр томъёоны чанарыг тодорхойлолтын чанараар тодорхойлно.

2. Нэр томъёоны тодорхойлолтод хийсэн задлан шинжлэл

Монгол Улсын стандартуудаас судалгааны хэрэглэгдэхүүн болгон авсан 85 стандартын 10421 нэр томъёоны тодорхойлолтыг энэхүү өгүүллийн 3.2-т дурдсан стандарт шаардлагад нийцэж буй эсэхийг агуулгын болон хэлбэрийн талаас нь авч үзсэн болно. Ингэхдээ хөмрөгт буй стандарт шаардлага хангаагүй тодорхойлолтын заримыг жишээ болгон тайлбарлалаа.

2.1. Тодорхойлолтын агуулгад хийсэн задлан шинжлэл

Бид энэ хэсэгт судалгааны хэрэглэгдэхүүн болгон авсан 10421 нэр томъёоны тодорхойлолтыг агуулгын хувьд 3.2-т заасан шаардлагыг хангаж буй эсэх болон зарим алдаа дутагдлыг олж илрүүлэн тэдгээрийн зөв хувилбарыг санал болгох зорилготой.

Олон улсын стандарт шаардлагад зааснаар, тодорхойлолт нь тодорхойлуулж буй ухагдахууныг ижил төстэй ухагдахуунаас заагласан байх ёстой. Энэ шаардлагыг хангахын тулд тодорхойлолт нь тухайн ухагдахууны зөвхөн чухал буюу бусдаас онцлог шинж чанарыг агуулсан байх ёстой. Гэтэл бидний судалгааны хэрэглэгдэхүүнд хоёр өөр нэр томъёог нэг ижил тодорхойлсон 6 тохиолдол байна. Жишээ нь:

- (1) *Уураар гал унтраах төхөөрөмж: Уураар гал түймэр унтраах автомат тоног төхөөрөмж* (MNS 0639: 2016);
- (2) *Хийгээр гал унтраах төхөөрөмж: Уураар гал түймэр унтраах автомат тоног төхөөрөмж* (MNS 0639: 2016) гэх мэт тохиолдол байна.

Жишээ 1, 2-оос харахад, *Уураар гал унтраах төхөөрөмж, Хийгээр гал унтраах төхөөрөмж* гэсэн хоёр нэр томъёо нэг тодорхойлолттой байгаа нь хоёр өөр нэр томъёо нэг ухагдахууныг нэрлэж байна гэсэн үг юм. Гэтэл монгол хэлний *уур, хий* хэмээх хоёр үг нь ойролцоо утгатай боловч яг адилхан ухагдахууныг заахгүй, уур гэдэг нь усны гурван төлөвийн нэг болох хийн төлөв юм. Харин хий гэдэг нь тодорхой хэлбэр дүрс, эзлэхүүнгүй бодисын нэгэн төлөв. Тиймээс ухагдахууны тогтолцооны хувьд хий нь ерөнхий, уур нь хийн нэгэн төлөв буюу тусгай ухагдахуун гэсэн үг юм. Тиймээс дээрх хоёр нэр томъёоны хувьд тодорхойлолт нь ижил байж болохгүй юм. Хэрвээ тухайн хоёр нэр томъёо

нэг ухагдахууныг нэрлэсэн хувилбар нэр томьёо бол нэгийг нь хэрэглэхээр стандартчилж жигдлэх хэрэгтэй юм.

Эсрэгээрээ, нэг ухагдахууныг илэрхийлсэн нэр томьёо өөр өөр салбарт болон нэг салбарт харилцан адилгүй тодорхойлолттой байна. Ийм 27 тохиолдол байна. Жишээ нь: “газар” хэмээх нэр томьёог “Байгаль хамгаалал. Газар, Газар ашиглалтын нэр томьёо”-нд

- (3) *Газар: Хөрс, ургамал, ус, ашигт малтмалын арвин баялаг бүхий улс ардын аж ахуйн төрөл бүрийн салбарыг байрлуулахад ялангуяа гол суурь хэрэглүүр нь болдог бидний хүрээлэн байгаа орчны хамгийн чухал хэсгийг хэлнэ* (MNS 3473: 1983) гэж тодорхойлсон бол, “Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт”-ийн нэр томьёонд
- (4) *Газар: Газрын гадаргуу, түүний хөрс, ой, ус, ургамал бүхий орон зайн давхарга* (MNS 5914: 2008) гэж тодорхойлсон нь хоёр өөр ухагдахууныг тодорхойлсон мэт болжээ. Жишээ (3)-г “газар”-ыг хэтэрхий нуруу атлаа ухагдахууныг онож тодорхойлоогүй байна. Энэ мэтээр нэр томьёог салбар хооронд төдийгүй салбар дотор өөр өөрөөр тодорхойлох нь үл ойлголцол, төөрөгдөл үүсгэх сөрөг талтай тул жигдлэх цэгцлэх зайлшгүй шаардлагатай юм.

Тодорхойлолт нь ухагдахуунтай пропорциональ байх ёстой, өөрөөр хэлбэл хэт ерөнхий юм уу эсвэл хэт нарийвчилсан байх ёсгүй гэсэн шаардлага бий. Бидний судалгаанаас үзэхэд, стандартчилсан нэр томьёоны нийт тодорхойлолтоос тухайн ухагдахууныг хэт ерөнхий буюу онцлог шинжийг нь сайтар тодорхойлоогүй тохиолдол 96 байна. Жишээ нь:

- (5) *Дуулга малгай: Гаднын гэмтлээс хүн нэг бүрийг хамгаалах хэрэгсэл* (MNS 0639: 2016);
- (6) *Хошуувч: Амьсгалахад хүнд орчинд ажиллахад хамгаалах хэрэгсэл* (MNS 0639: 2016);
- (7) *Данс хоорондын гуйвуулга: Шуудангийн санхүүгийн үйлчилгээнд хэрэглэгддэг* (MNS 0515: 2015) гэх мэт.

Жишээ (5)-д “дуулга малгай”-н онцлог шинж чанарыг тодотголгүйгээр ерөнхийлөн тодорхойлсон нь гаднын нөлөөнөөс хамгаалах бусад хэрэгслээс ялгаагүй байна. Зүй нь, *Гаднын нөлөөнөөс шалтгаалан толгой гэмтэхээс хамгаалж өмсөх төмөр малгай* гэж тодорхойлох хэрэгтэй. Жишээ (6)-д мөн “хошуувч”-ийг *Амьсгалахад хүнд орчинд ажиллахад хамгаалах хэрэгсэл* хэмээн тодорхойлсон нь тухайлбал, хорт утааны багаас юугаараа ялгаатайг тодотгоогүй байна. Зүй нь, *Амьсгалахад хүнд орчинд ажиллахад ам хамарт өмсөж хамгаалах хэрэгсэл* гэж хошуунд зүүдэг гэдгийг тодотгох шаардлагатай юм. Жишээ (7)-д “Данс хоорондын гуйвуулга”-ыг шуудангийн санхүүгийн үйлчилгээнд хэрэглэдэг чухам юу болохыг тодотгоогүй буюу дутуу тодорхойлсон байна. Энэхүү нэр томьёо нь шуудан үйлчилгээнд харьцангуй шинэ тутам бий болсон ухагдахууныг тэмдэглэж буй ажээ. Тиймээс уг ойлголт ухагдахууныг сайтар тодорхойлон бичиж байж түүний тухай бусдад бүрэн гүйцэд мэдлэг өгөх болно.

Хэт ерөнхийлсөн жишээнээс гадна хэт нарийвчилсан 34 тодорхойлолт байна. Жишээ нь:

(8) *Дардас дарах: Марк хүчингүй болгох* (MNS 0515: 2015) гэсэн энэ тодорхойлолт нь дардсыг зөвхөн марк хүчингүй болгоход дардаг мэт ойлгогдохоор байна. Гэтэл дардас дарах нь түүнээс илүү өргөн хүрээтэй ухагдахуун юм. Өөрөөр хэлбэл, энэ тодорхойлолт нь ухагдахууныг хэт нарийвчилж явцууруулан илэрхийлсэн байна.

Түүнчлэн тухайн нэр томъёогоор илэрч буй ухагдахууныг хэт явцууруулан тодорхойлсон

(9) *Модны үүлдэр: Модлог ургамлын төрөл* (MNS 4118: 1991);

(10) *Ой модны дундаж өндөр: Ойн модны дундаж өндрийг бүдүүний төвийн үеллүүдээс авсан моддын арифметик дундаж өндрөөр тогтооно* (MNS 4118: 1991);

(11) *Гагнаасан гүүр: Металл гүүр дамнуур нь гагнаастай* (MNS 6387-1: 2013);

(12) *Төмөр замын байгууллага: Суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгчийг* (MNS 6387-1: 2013) гэх мэт олон жишээг дурдаж болно.

Ухагдахууны тогтолцоонд тодорхойлолтууд нь агуулгын хувьд хоорондоо маш сайн холбоотой байх ёстой. Жишээлбэл:

Хүснэгт 1. Ухагдахууны тогтолцоот зарим тодорхойлолтын жишээ
(MNS 0639: 2016)

Монгол нэр томъёо	Англи нэр томъёо	Тодорхойлолт
Гал түймэр унтраах хоолой	Fire hose	Гал түймэр унтраах бодисыг өндөр даралтын үйлчлэлээр шахах, сорох зориулалтай уян ба хатуу хоолой
Гал түймэр унтраах даралтын хоолой	Pressure hose	Гал түймэр унтраах бодисыг өндөр даралтын нөлөөгөөр дамжуулах уян хоолой
Гал түймэр унтраах соролтын хоолой	Suction hose	Гал түймэр унтраах бодисыг өндөр даралтын нөлөөгөөр сорох хатуу хоолой

“Гал түймэр унтраах хоолой” гэсэн ерөнхий нэр томъёо нь бусад хоёр тусгай ухагдахууны ерөнхий шинж чанарыг агуулсан, агуулгын хувьд илүү өргөн хүрээтэй тодорхойлолттой байгааг Хүснэгт 3-аас харж болно. Харин хоёр тусгай ухагдахууныг тэмдэглэсэн *гал түймэр унтраах даралтын хоолой, гал түймэр унтраах соролтын хоолой* гэсэн нэр томъёоны тодорхойлолт нь бие биеэсээ ялгарах шинжийг нь нарийвчлан харуулсан байна.

Стандарт шаардлагаар тодорхойлолт нь тойрог буюу эргэж буцсан угтаттай байж болохгүй. Гэтэл стандартчилсан нэр томъёонд ийм төрлийн тодорхойлолт 65 байгаагаас заримыг дурдвал:

- (13) *Мэдээлэл авах: Хадгалагдсан өгөгдлөөс тодорхой мэдээлэл авах үйлдэл, арга, үйл ажиллагаа.* (MNS ISO 2392-1:1999);
- (14) *Газардуулагч: Газардуулагч буюу газартай холбогдох дамжуулах утас буюу электрод* (MNS 5350: 2003);
- (15) *Өнгөр хамах: Өнгөрийг нэгмөсөн хамах үйл явц* (MNS ISO 1998-4: 2008);
- (16) *Тэргэнцэр дээр суурилуулсан гал унтраагуур: Дугуйтай тэрэг дээр суурилуулсан гал унтраагуур* (MNS 0639: 2016);
- (17) *Богцыг битүүмжлэн боох хэсэг: Богцыг битүүмжлэхэд зориулсан хэсэг* (MNS 0515: 2015);
- (18) *Хаягт эзэн: Илгээмжийг хүлээн авах хаягт эзэн* (MNS 0515: 2015);
- (19) *Үйс: Үйсэн модны их бие ба салаа мөчрийн холтсыг нь үечлэн хуулж үйсэн бүтээгдэхүүний түүхий эдээр хэрэглэдэг* (MNS ISO 9229: 2010);
- (20) *Зууралданги чанарыг багасгах: Эцсийн бүтээгдэхүүнийг гарган авсны дараа ялгарч үлдэж буй бага молекул масстай бүтээгдэхүүнийг түүхий эдтэй нь харьцуулахад зууралданги чанар нь багассан байдаг* (MNS ISO 1998-4: 2008);
- (21) *Гарам хаах тушаал: Гармыг албадан хаах тушаал* (MNS 6387-2: 2013);
- (22) *Нугасан аралтай өөрөө буулгагч: Өөрөө буулгагч нь жолоодлогын нугасан аралтай байна* (MNS ISO 4306-2: 2010) гэх мэт тодорхойлолтод тодорхойлуулж буй нэр томъёог тэр чигт нь хэрэглэсэн байгаа тул учир зүйн тойргийг үүсгэжээ.

Түүнчлэн үг буруу сонгосон, үг илүүдсэн, үг дутсан, үг давтсан, үгийн өнгө аяс гажсан гэх мэт найруулгын алдаатай 298 тодорхойлолт байна. Жишээ нь:

а) Үг буруу сонгосон:

- (23) *Гутал: Хөлийг гадаад орчны нөлөөнөөс хамгаалахад зориулагдсан хэрэгцээний ба гоо зүйн үүрэг гүйцэтгэх эдлэхүүн* (MNS 3838: 1985)
- (24) *Гутлын загвар: Гадаад (хэлбэр) ба материал, зохион бүтээлтийн өөрийн өвөрмөц ялгагдах шинжийг агуулсан тодорхой эдлэхүүн* (MNS 3838: 1985) гэсэн дээрх хоёр тодорхойлолтод “гутал”, “гутлын загвар” гэсэн хоёр нэр томъёог хоёулыг нь эдлэхүүн хэмээн тодорхойлсон нь учир дутагдалтай байна. Учир нь *гутал* бол хөлийн өмсгөл харин *гутлын загвар* бол тухайн хөлийн өмсгөлийн хэв маягийг нэрлэж буй тул уг хоёр нэр томъёо нь илэрхийлж буй ухагдахууны хувьд огт өөр юм. Өөрөөр хэлбэл, дээрх хоёр тодорхойлолт нь “эдлэхүүн” гэдэг үгийг хэрэглэснээрээ тодорхойлуулж буй ерөнхий-тусгайн харьцаатай хоёр ухагдахууныг параллель буюу ижил түвшний ухагдахуун мэт тодорхойлсон нь танин мэдэхүйн хувьд буруу ойлгогдохоор болжээ. Иймээс дээрх хоёр тодорхойлолтыг дахин найруулан бичих шаардлагатай. Зүй нь, *гутал: Хөлийг гадаад орчны нөлөөнөөс хамгаалах*

зорилгоор өмсдөг өмсгөл гэж; гутлын загвар-ыг Гутлын материал, гадаад хэлбэр, хийцийг үзүүлсэн үлгэр маяг хэмээн тодорхойлбол, илүү ойлгомжтой болно. Түүнчлэн

(25) *Шатах*: Хяналтын доор явуулдаг зориудын шаталга (MNS 3838: 1985) гэсэн тодорхойлолт нь үг буруу сонгосон найруулгын алдаатай байна. Тодруулбал, хэрвээ ямар нэг зүйлийг зориуд шатааж буй бол “зориудын шаталга” гэж бичих нь учир зүйн хувьд буруу болно. Түүнчлэн тодорхойлолтын агуулгыг харвал, түүгээр илэрхийлэгдэж буй нэр томъёо нь “*шатах*” биш харин “*шатаах*” байх ёстой. Тиймээс уг нэр томъёо, тодорхойлолтыг “*Шатаах*”: “*Ямар нэг зүйлийг зориуд хяналттай галдах*” гэж засах хэрэгтэй.

b) Үг дутсан:

(26) *Нүүрлэгч*: *Хаягтай талыг нэг тийш нь харуулж эмхлэх* (MNS 0515: 2015);

(27) *Тавиур*: *Овор, жин ихтэй шуудан, шуудангийн илгээмжийг зөөвөрлөх зориулалттай* (MNS 0515: 2015) гэсэн хоёр тодорхойлолтод “нүүрлэгч”, “тавиур” гэсэн хоёр субъектийг тодорхойлох нэр үгийг дутуу бичжээ. Зүй нь: *Нүүрлэгч*: *Хаягтай талыг нэг тийш нь харуулж эмхлэх үүрэгтэй ажилтан*; *Тавиур*: *Овор, жин ихтэй шуудан, шуудангийн илгээмжийг зөөвөрлөх зориулалттай хэрэгсэл* гэж тодорхойлох хэрэгтэй. Түүнчлэн зарим тодорхойлолтод чухам юу вэ гэдгийг тодорхойлолгүй, өгүүлбэрийг гүйцээлгүй дутуу бичсэн нэлээд хэдэн тохиолдол байна. Жишээ нь:

(28) *Бээлий*: *Илгэн нэхийгээр буюу нэхмэл зүймэл дотортой даавуугаар гадарлаж хийсэн* (MNS 3843:1985);

(29) *Сортой малгай*: *Нэхийний үсийг сор тавьж будаж хийсэн* (MNS 3843:1985) гэх мэт.

c) Үгийн өнгө аяс гажсан:

(30) *Голын урсгалыг шахах*: *Гүүрэн гарцаар голын амьд урсгалын огтлолцыг багасгана* (MNS 6387-1: 2013) гэсэн тодорхойлолтод “голын амьд урсгал” гэсэн холбоо үг хэрэглэснээр үгийн өнгө аяс гажсан найруулгын алдаа болжээ. Бид төмөр замын мэргэжилтэн биш тул “голын амьд урсгал” гэж чухам юуг хэлж буйг мэдэхгүй. Гэвч монгол хэлэнд “*голын амьд урсгал*”, “*үхсэн урсгал*” гэсэн үг байж болохгүй юм. Түүнээс гадна дээрх өгүүлбэр нь тодорхойлолт биш, тайлбар байна. Тиймээс мэргэжлийн хүмүүс энэ тодорхойлолтыг дахин боловсронгуй болгож бичих хэрэгтэй.

d) Үг илүүдсэн:

(31) *Сурах бичгийн зохиогч*: *Сурах бичгийн судлаач, арга зүйч, мэргэжлийн багш, редактор, дизайнер зэрэг төлөөллөөс бүрдсэн зохиогчийн баг* (MNS 5418: 2008) гэсэн тодорхойлолтод “*зохиогчийн баг*” гэдэг үг илүүджээ. Учир нь “*сурах бичгийн зохиогч*” гэсэн нэр томъёо нь бүлэг хүнийг илэрхийлээгүй

сурах бичиг зохиоход оролцсон нэг хүнийг нэрлэж буй. Энэ тодорхойлолт нь ангиллын хувьд хүрээний тодорхойлолтод багтана. Тодруулбал, сурах бичгийн зохиогч гэсэн хүрээнд хэн хэн багтаж болохыг тодорхойлсон байна. Зүй нь: “Сурах бичгийн зохиогч: Дунд сургууль, их дээд сургуульд боловсрол олгох зорилгоор хэрэглэх сурах бичгийн загварыг гаргаж, агуулгыг боловсруулан бичих мэргэжилтэн” гэж тодорхойлоод нэмэлт тайлбарт “Сурах бичиг зохиогчийн баг нь судлаач, арга зүйч, мэргэжлийн багш, редактор, дизайнер зэрэг төлөөллөөс бүрдэнэ” гэж болно.

Дээр дурдсанчлан, тодорхойлолт нь сөрөг утгатай байж болохгүй. Бидний судалгааны хэрэглэгдэхүүнд буй ийм төрлийн 7 тодорхойлолтоос зарим жишээг дурдвал,

(32) *Хөшилт*: Бие буюу бүтээцийн хэв гажилтыг эсэргүүцэх чадвар, хатуулгийн эсрэг хэмжээг уян гэж нэрлэдэг (MNS 6387-1: 2013) гэсэн тодорхойлолтод тодорхойлуулж буй нэр томъёоны эсрэг утгатай “уян” гэсэн үгээр тайлбарласан нь буруу юм. Харин “хөшилт” гэж чухам ямар үйл явц болохыг тодорхойлох ёстой.

(33) *Хориотой хог ургамал*: Тухайн нутагт тархаагүй, устгахад бэрхиээлтэй онцгой аюултай хог ургамал (MNS 3472: 1983) гэсэн тодорхойлолтод хэрвээ тухайн нутагт тархаагүй юм бол устгах тухай ярих хэрэггүй. Өөрөөр хэлбэл, дээрх тодорхойлолт учир зүйн алдаатай тодорхойлолт болжээ.

Мөн зарим тодорхойлолтыг ажиглахад, тодорхойлолт гэхээс илүү тухайн нэр томъёоны хувилбарыг бичжээ. Ийм тодорхойлолт 79 байна. Жишээ нь:

(34) *Брошюр*: Хэвлэмэл хуудас (MNS 0515: 2015);

(35) *Хурган үс*: Нарийн, нарийвтар ноос (MNS 3362: 1982);

(36) *Баадагнах*: Хэсэг хэсгээр нь боох (MNS 0515: 2015) гэх мэт нэг нэр томъёог нөгөөгөөр орлуулан бичсэн нь тодорхойлолтын шаардлагад нийцэхгүй. Тухайлбал, “хурган үс”-ийг *нарийн нарийвтар ноос* гэж тодорхойлсон нь хэт ерөнхий буюу бусад насны хонины нарийн ноосноос ялгарах онцлогийг бичээгүй тул нэр томъёоны утгыг бүрэн илэрхийлж чадахгүй юм.

2.2. Тодорхойлолтын хэлбэрт хийсэн задлан шинжлэл

Бид энэ хэсэгт МУ-ын стандартчилсан нэр томъёоны тодорхойлолтуудыг хэлбэрийн талаас стандарт шаардлагад нийцэж буй эсэхийг задлан шинжилж үзнэ.

Тодорхойлолт нь тодорхойлох гэж буй нэр томъёо буюу тэмдэглэх нэр томъёогоор эхэлж болохгүй. Өөрөөр хэлбэл, “/Нэр томъёо/ нь, гэж, гэдэг нь ...” гэсэн хэлбэртэй байж болохгүй. Судалгаанаас үзэхэд, стандартчилсан нэр томъёоны санд “/Нэр томъёо/ гэдэг нь ...” гэж эхэлсэн 22 тодорхойлолт байна. Жишээ нь:

- (37) Химийн бохирдолт: **Химийн бохирдолт гэдэг нь** зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн химийн хорт болон аюултай бодисын нөлөөгөөр аливаа орчин бохирдохыг;
- (38) Үйлчлэлийн хүчний нөлөө: **Үйлчлэлийн хүчний нөлөө гэдэг нь** бүтээцийн хэсэг дээрх үйлчлэлийн нөлөө юм: дотоод момент ба хүчнүүд /M, N, V, T гэх мэт / зэрэг байна.

“/Нэр томъёо/ нь ...” гэж эхэлсэн 12 тодорхойлолт байна. Жишээ нь:

- (39) Сурах бичиг: **Сурах бичиг нь** боловсролын стандарт ба куррикулумыг хэрэгжүүлэх зориулалттай суралцахуй ба багшлахуйн нэгдлийг хангахад шаардлагатай онол, арга зүйн үндэс бүхий дидактик шийдлийг цогцоор хэлбэржүүлсэн сургалтын үндсэн хэрэглэгдэхүүн;
- (40) Найдваршил: **“Найдваршил” нь** бүтээцийн аюулгүй байдал, ашиглалтын хэвийн нөхцөл, эдэлгээний хугацааг хамаарна;

“/Нэр томъёо/ гэж ...” гэж эхэлсэн 54 тодорхойлолт байна. Жишээ нь:

- (41) Ул шороо: **Ул шороо гэж** газрын гадаргыг боловсруулах замаар байгуулсан инженерийн иж бүрэн шороон байгууламжийг хэлнэ. гэх мэт.

Мөн тодорхойлолтын төгсгөл нь олон янзын хэлбэртэй байна. Тухайлбал, стандартчилсан нэр томъёоны хөмрөгт заахын тийн ялгалын нөхцөлөөр төгссөн 174, “хэлнэ” хэмээх үгээр төгссөн 166, “юм” хэмээх үгээр төгссөн 150, “гэнэ” хэмээх үгээр төгссөн 68, “болно” хэмээх үгээр төгссөн 67, “гэдэг” хэмээх үгээр төгссөн 5 байна. Жишээ нь:

- (42) Химийн аюултай бодис алдагдах гэдэг нь техник, тоног төхөөрөмжийн битүүмжлэл болон технологийн горим алдагдсаны улмаас богино хугацаанд химийн аюултай бодис осол үүсгэх хэмжээнд **ялгарахыг** (MNS 6010: 2016)
- (43) Төмөр замын аюултай бүс: Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөн, ачилт, буулгалтын ажил гүйцэтгэдэг дэвсгэр **газрыг** (MNS 6387-1: 2013);
- (44) Үнэгүйдэх: Нөхөн төлөгдөх үнэ нь дансны үнээс бага болтол буурахыг **хэлнэ** (MNS 5242: 2003).
- (45) Мэдэгдэхүйц нөлөөлөл: Санхүүжигчийн санхүүгийн болон үйл ажиллагааны бодлогыг тодорхойлоход оролцох бөгөөд бодлогод хяналт тавихгүй байх эрх **юм** (MNS 5242: 2003).
- (46) Гудамлаг (хагас хонгил): Дээд талаараа буюу аль нэгэн талаараа зузаан хөрсөнд далдлагдаагүй ил задгай аргаар барьж болох уулын төхөөрөмжийн нэгэн хэлбэрийг **гудамлаг гэнэ** (MNS 6387-1: 2013);
Динамик зууралдлага: Урсалтын хурд болон дотоод үрэлтээс үүсэх эсэргүүцлийг динамик **зууралдлага гэнэ** (MNS ISO 1998-2:2008);
- (47) Зээлийн зардал: Байгууллагын хөрөнгө зээлдэн авахтай холбогдож үүссэн хүү болон бусад зардал **болно** (MNS 5242: 2003);
- (48) Үр ашигт хүүгийн хувийг заримдаа дуусгавар болох хугацааны үр ашигийн

түвшин гэж томъёолохоос гадна санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн үр ашгийн хувь гэдэг.

(49) *Үйлчилгээний борлуулалт: Худалдаа үйлчилгээний ерөнхий гэрээний дагуу шуудангийн үйлчилгээг борлуулах гэж нэрлэнэ* (MNS 0515: 2015) гэх мэт стандартчилсан нэр томъёоны тодорхойлолт нь олон янзын төгсгөлтэй байна.

Тодорхойлолт нь тодорхойлуулж буй нэр томъёогоор төгсөж болохгүй. Судалгаанаас үзэхэд, энэ дүрмийг зөрчсөн 35 тохиолдол байна. Жишээ нь:

(50) *Хэт атираатай ноос: Атирааны өндөр нь суурь хэсгээсээ илүү гарсан хэт атираатай ноос* (MNS 3362: 1982);

(51) *Алх: Өөрийн жингээр цохилтын энергийг үүсгэдэг алх* (MNS ISO 11375: 2000);

(52) *Гадас хэвлэх төхөөрөмж: Өрөмдөж гаргасан цооногт гадас хэвлэх төхөөрөмж* (MNS ISO 11375: 2000);

(53) *Богц: Төгсгөлийн богц буюу шуудангийн дагалдах бичиг баримт бүхий богц* (MNS 0515: 2015);

(54) *Гүйдэл дамжуулагч: Цахилгаан станц, дэд станцын хүрээнд цахилгаан эрчим хүчийг дамжуулах хуваарилах зориулалттай шин, тусгаарлагатай (бүрээстэй) ба тусгаарлагагүй утас хэлбэрээр хийсэн гүйдэл дамжуулагч* (MNS 5350: 2003);

(55) *Ил уурхай: Ул шороог байгуулахад өргөн хэрэглэгдэх өнгөн хөрсөнд ойрхон ашигт малтмалыг гаргаж авах ил уурхай* (MNS 6387-1: 2013) гэх мэт жишээ олныг дурдаж болно.

Тодорхойлолтын төгсгөл нь нэр томъёотой ижил хэл зүйн хэлбэртэй байна. Тиймээс үйл үгийг тодорхойлохдоо үйл үгээр; нэр үгийг тодорхойлохдоо нэр үгээр төгсгөх ба нэр нэр томъёог тодорхойлохдоо ганц тоог хэрэглэнэ. Стандартчилсан нэр томъёоны санд энэхүү дүрмийг зөрчсөн 45 тодорхойлолт байна. Жишээ нь:

(56) *Мөчир: Үндсэн шинээс салбарлаж модоожсон салаа хэсгүүд* (MNS ISO 8966: 2002) гэсэн тодорхойлолт нь олон тооны нөхцөл бүхий нэр үгээр төгссөн байна. Зүй нь, *Модны үндсэн шинээс салбарлаж ургасан салаа хэсэг* гэж тодорхойлох хэрэгтэй.

Мөн тайлбар шинжтэй тодорхойлолт нийт тодорхойлолтын 23%-ийг эзэлж байна. Жишээ нь:

(57) *Мөсөн бүрхүүл: Хөрсний буюу голын, цасны ус гадаргууд үелэн хөлдөж мөсөн бүрхүүл үүсгэнэ* (MNS 6387-1: 2013).

(58) *Үр, суулгах материалыг дүрж ариутгах: Үр суулгах материалыг үр ариутгах уусмалд дүрж, дараа нь хатааж ариутгана* (MNS 3474: 2003).

(59) *Овойлт: Чигжээсний үе хөлдсөнөөс замын дагуу огтлолд хэсэгхэн газрын эрчимтэй гажиг гарах ба ул шорооны хөрс хөлдсөнөөс гүний овойлт гарна* (MNS 6387-1 : 2013).

- (60) *Клапангийн механизмын гэр: Клапаны механизмын түүний орчныг хаасан* (MNS ISO 7967-1:2000).
- (61) *Шилэн утаслаг материал: Хайлуулсан шилнээс утаслаг ширхэглэлтэй хэлбэрээр үйлдвэрлэдэг материал ба арматурчлалын тор болон сүлжмэл материалд хэрэглэнэ* (MNS ISO 9229: 2010).
- (62) *Эрдэслэг /эрдсийн/ тос: Байгалийн байдлаараа илэрсэн эсвэл эрдсийн гаралтай материалыг боловсруулах аргаар гаргаж авсан* (MNS ISO 1998-1: 2008).
- (63) *Рейдийн уурын даралт: Рейдийн аргаар туршилтын температурын дор хий ба шингэн фазуудын эзлэхүүний харьцаа ба ханасан уурын даралтыг тодорхойлно* (MNS ISO 1998-2: 2008).
- (64) *Ботинк, Туфли: Түрийний өндөр нь хөлийн шагайнаас доогуур байна* (MNS 0096: 1982).
- (65) *Урт түрийтэй гутал: Хөлийн булчинг бүрэн хаасан урт түрийтэй байна* (MNS 0096: 1982).
- (66) *Гагнаасан холбоостой дамнуур: Металл дамнуур, бүх холбооснууд нь гагнаасаар бэхлэгдсэн байна* (MNS 6387-1 : 2013);
- (67) *Цэвэрлэлт: Үндсэн бүтээгдэхүүнийг бусад хольцоос нь цэвэрлэнэ* (MNS 3472: 1983);
- (68) *Аюулгүй байдал, бүтээцийн аюулгүй байдал: Энэ нэр томъёо одоог хүртэл найдваршлын ойлголтод ихэнхдээ хэрэглэсээр байгаа. Энэхүү хязгаарлагдмал ойлголтод бүтээц нь бүх үйлчлэлийг эсэргүүцэх чадвартай, үйлдвэрлэх угсрах болон ашиглалтын үед осолтой үзэгдлийг сэрэмжилсэн байхаар нарийн тодорхойлох явдал багтана. /Хязгаарын төлөвийн I бүлэгтэй холбоотой гэх мэт олон жишээг дурдаж болно.*

Зүй нь, “Мөсөн бүрхүүл”-ийг “Хөрсний гадаргууд үелэн хөлдсөн голын болон цасны ус”; “Ботинк, Туфли”-ийг “Түрийний өндөр нь хөлийн шагайнаас доогуур, дулааны улиралд хэрэглэдэг хөлийн өмсгөл”; “Урт түрийтэй гутал”-ыг “Хөлийн булчинг бүрэн хаасан, хүйтний улиралд хэрэглэдэг хөлийн өмсгөл” гэх мэтээр тодорхойлж болно.

3. Судалгааны үр дүн

Бид энэ удаагийн судалгаандаа Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй 85 стандартын 10421 нэр томъёоны тодорхойлолтыг агуулга, хэлбэрийн хувьд стандарт шаардлагад нийцэж буй эсэхийг задлан шинжилж үзээд дараах алдаа дутагдал байгааг олж илрүүлээ. Үүнийг хүснэгтээр нэгтгэн үзүүлбэл дараах байдалтай байна.

Хүснэгт 2. Агуулгын талаас задлан шинжилсний үр дүн

Тодорхойлолт	Тоо	Хувь
Хоёр өөр нэр томъёог нэг ижил тодорхойлсон	6	0.05
Нэг нэр томъёог хоёр өөрөөр тодорхойлсон	27	0.2

Хэт ерөнхий тодорхойлсон	96	0.9
Хэт нарийвчлан тодорхойлсон	34	0.3
Тойрог тодорхойлолт	42	0.4
Найруулгын алдаатай тодорхойлолт	298	2.8
Нэр томьёоны хувилбар мэт тодорхойлолт	79	0.7
Сөрөг утгатай тодорхойлолт	7	0.06
Агуулгын алдаатай нийт тодорхойлолт	589	5.6%

Хүснэгт 3. Хэлбэрийн талаас задлан шинжилсний үр дүн

Тодорхойлолт	Тоо	Хувь
“/Нэр томьёо/ гэдэг нь ...” гэж эхэлсэн	22	0.2
“/Нэр томьёо/ гэж ...” гэж эхэлсэн	54	0.5
“/Нэр томьёо/ нь ...” гэж эхэлсэн	12	0.1
Заахын тийн ялгалаар төгссөн	174	1.6
“хэлнэ” хэмээх үгээр төгссөн	166	1.5
“юм” хэмээх үгээр төгссөн	150	1.4
“гэнэ” хэмээх үгээр төгссөн	68	0.6
“болно” хэмээх үгээр төгссөн	67	0.6
“гэдэг” хэмээх үгээр төгссөн	5	0.04
“гэж нэрлэнэ” хэмээн төгссөн	5	0.04
тодорхойлуулж буй нэр томьёогоор төгссөн	35	0.3
тодорхойлуулж буй нэр томьёоноос өөр хэл зүйн хэлбэртэй үгээр төгссөн	45	0.4
Тайлбар шинжтэй тодорхойлолт	2397	23
Хэлбэрийн алдаатай нийт тодорхойлолт	3200	30.7%

4. Дүгнэлт

Тодорхойлолт нь аливаа нэг салбарын ойлголт ухагдахууныг илэрхийлсэн өгүүлбэр бөгөөд нэр томьёо судлалын онолын болон практик үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэдэг ажээ. Иймд тодорхойлолтыг зөв, оновчтой бичих нь тухайн ухагдахууныг зөв ойлгож танин мэдэхэд чухал юм.

Бидний судалгаанаас үзэхэд, Монгол Улсын стандартууд дахь нэр томьёонд агуулгын болон хэлбэрийн хувьд стандарт шаардлага хангаагүй, ухагдахууны тогтолцоог харгалзаагүй, салбар дотор болон салбар хооронд нэг ухагдахууныг өөр өөрөөр тодорхойлсон, давхцал ихтэй байгаа нь ажиглагдлаа. Нийтээр дагаж мөрдөх ёстой стандарт нь ийм учир дутагдалтай, нэгдсэн стандартгүй байгаа нь тухайн нэр томьёогоор тэмдэглэсэн ухагдахууныг буруу ойлгох, улмаар үйлдвэрлэлийн аюулгүй байдал, эдийн засгийн үр нөлөө зэрэгт муугаар нөлөөлөх дам шалтгаан болно.

Шинжлэх ухааны нэр томьёог иргэд болон судлаачид нэгдсэн нэг ойлголт, ухагдахуунаар ойлгож, шинжлэх ухааны үндэслэлтэй, судалгаанд суурилсан

үнэн зөв мэдлэгийг олон нийтэд таниулах, эзэмшүүлэх нь шинжлэх ухааны ач холбогдолтой юм. Улмаар мэдлэгийн нэгж болсон нэр томъёог боловсронгуй болгож, цэгцлэн жигдлэх нь шинжлэх ухааны мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх, боловсролыг чанаржуулах, мэдлэгийн менежмент, инженерчлэл, хиймэл оюун ухаан, инновацыг хөгжүүлэх суурь болно.

Тиймээс энэ бүх асуудлыг үе шаттай, тогтолцоотой засаж сайжруулах, нэр томъёоны стандартыг боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай болжээ. Үүний тулд Хэлний бодлогын үндэсний зөвлөл, Улсын нэр томъёоны комисс, Стандарт хэмжил зүйн газар, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн болон салбарын мэргэжилтнүүд хамтын ажиллагаа чухал байна.

Талархал

Энэхүү өгүүлэл нь Монгол Улсын Боловсрол, Шинжлэх Ухааны Яамны санхүүжилтээр хэрэгжиж буй [№ ШУТБИХХЗГ-2022/196] Монгол нэр томъёоны стандартын судалгаа (Нэр томъёо боловсруулах арга, зарчмын олон улсын стандартыг нутагшуулах) төслийн хүрээнд бичсэн судалгааны нэг хэсэг юм.

Стандартын нэр томъёоны хөмрөг бүрдүүлэхэд хамтран ажилласан Стандарт хэмжил зүйн газар, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Ажлын албаны хамт олонд баярлалаа.

Тус судалгааг хийхэд үнэтэй заавар, зөвлөгөө өгч, онолын ном бүтээл, эх сурвалжаар хангаж дэмжин ажилласан, “Монгол Улсын нэр томъёоны төлөвлөлтийн стратеги, нэр томъёоны дэд бүтцийг хөгжүүлэх” (КОЕФ 09/2019) хамтарсан төслийн гишүүн, профессор Кристиан Галински (Инфотерм) хатагтай Бланка Стелла (Инфотерм) нарт чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Ном зүй

- Christian Galinski** (1995). Terminology and Standardization for Machine Translation. *Proceedings of Machine Translation Summit V*, Luxembourg, Luxembourg. pp.45-63. Retrieved from: <https://aclanthology.org/1995.mtsummit-1.18.pdf>
- Felber, H.** (1984). *Terminology manual*. Paris: Unesco and Infoterm
- Georgios Floros and Simos Grammenidis** (2012). “Secondary Term Formation in Greek: Theoretical and Methodological Considerations.” *Terminology 18:1* 86-104.
- Гринеv-Гринеvич С.В.** (2008). *Терминоведение*. Москва: Академия. 308с. [Grinev-Grinevich S.V. Terminology. Moscow: Academy. 2008].
- Lušicky, Vesna, and Tanja Wissik.** (2015). *Procedural Manual on Terminology*. Translation-Oriented Terminology Work.
- Мөнхцэцэг, Н.** (2020) *Нэр томъёоны орчуулга судлал*. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК. [Munkhtsetseg, N. *Ner tomyony orchuulga sudlal* [Translation-Oriented Terminology Studies]. Ulaanbaatar: Soyombo Printing LLC. 2020]

- Новодранова, В.Ф.** (2008) *Именное словообразование в латинском языке и его отражение в терминологии*. Москва: Языки Славянских культур. 328с. [Novodranova, V.F. Nominal word formation in the Latin language and its reflection in the terminology. Moscow. 2008]
- Pamela Faber and Silvia Montero-Martínez** (2019). Terminology. *Routledge Handbook of Spanish Translation Studies*. Chapter 14. Retrieved from https://www.researchgate.net/publication/334112813_Terminology
- Seppälä, Selja** (2015). An ontological framework for modeling the contents of definitions.” *Terminology 21:1* 23-50.
- Salgado, A., Costa, R., and Tasovac, T** (2022). Applying Terminological Methods to Lexicographic Work: Terms and Their Domains. *Proceedings of the XX EURALEX International Congress*. Mannheim: IDS-Verlag. pp.181-195.
- TerminOrgs** (2016) *Terminology Starter Guide*. Retrieved from: https://www.terminorgs.net/downloads/TerminOrgs_StarterGuide_V2.pdf
- ISO 1087-1: 2019** Terminology Work and Terminology Science
- ISO 10241-1:** Terminological entries in standards - Part 1: General requirements and examples of presentation
- ISO 704: 2022** Terminology work - Principles and methods

Стандарт

- MNS 0639: 2016 – Гал түймэр унтраах, аврах тоног төхөөрөмж багаж болон тээврийн хэрэгслийн нэр томъёо ба тодорхойлолт
- MNS 0515: 2022 – Шуудан холбоо. Нэр томъёо
- MNS ISO 2392-1: 1999 – Мэдээллийн технологийн үндсэн ба ерөнхий нэр томъёо
- MNS 5350: 2003 – Цахилгаан станц, цахилгаан шугам сүлжээний цахилгааны хэсэг. Нэр томъёо, тодорхойлолт
- MNS ISO 1998-4: 2008 – Газрын тосны аж үйлдвэрийн нэр томъёо
- MNS 3838: 1985 – Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм. Нэр томъёо тодорхойлолт
- MNS 3472: 1983 – Газар тариалан
- MNS ISO 9229: 2010 – Дулаан тусгаарлах материал- Нэр томъёо, тодорхойлолт
- MNS 6387-1: 2013 – Төмөр зам. Зам, замын аж ахуйн нэр томъёо, тодорхойлолт
- MNS 6387-2: 2013 – Төмөр замын автоматик ба телемеханикийн нэр томъёо, тодорхойлолт
- MNS 6387-4: 2016 – Төмөр замын тээврийн удирдлага, зохион байгуулалтын нэр томъёо, тодорхойлолт
- MNS ISO 4306-2: 2010 – Кран толь бичиг: Өөрөө явагч кран
- MNS 4118: 1991 – Ойн нэр томъёо, тодорхойлолт
- MNS 5418:2008 – Мэдээллийн шинжлэх ухаан, хэвлэлийн нэр томъёо
- MNS 6010: 2016 – Гамигийн холбогдолтой нэр томъёо, тодорхойлолт
- MNS ISO 1998-2: 2008 – Газрын тосны аж үйлдвэр. Нэр томъёо. 2-р хэсэг: Газрын тосны бүтээгдэхүүний физик, химийн шинж чанарын үзүүлэлт

MNS 3362: 1982 – *Ноосны анхан шатны боловсруулалт: Нэр томъёо, тодорхойлолт*

MNS ISO 11375: 2000 – *Барилгын машин төхөөрөмж: Нэр томъёо, тодорхойлолт*

MNS ISO 8966: 2002 – *Мод бэлтгэх үйлдвэр – Бүтээгдэхүүн: Нэр томъёо, тодорхойлолт*


MNS 3474: 2003 – *Ургамал хамгаалал: Нэр томъёо, тодорхойлолт*

MNS ISO 7967-1: 2000 – *Дотоод шаталтын хөдөлгүүр – Тайлбар толь Бүрдүүлэгч ба системийн тайлбар толь 1-р хэсэг. Бүтцийн суурь эд анги ба гадаад хамгаалалт*

MNS ISO 9229: 2010 – *Дулаан тусгаарлах материал - Нэр томъёо, тодорхойлолт*

MNS ISO 1998-1: 2008 – *Газрын тосны аж үйлдвэр – Нэр томъёо 1-р хэсэг: Түүхий эд материал ба бүтээгдэхүүн*

MNS 0096: 1982 – *Гутал: нэр томъёо, тодорхойлолт*



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.